



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/319

Арвайхээр

**Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх
авах арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29 дүгээр зүйлийн 29.1.6."б", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Улсын Онцгой комиссын 05 дугаар албан даалгавар, Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 02 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг эрчимжүүлж, хэрэгжилт, үр дүнг тооцох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: А.Балжинням (аймгийн Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, ахмад)

Гишүүдэд: Б.Нацаг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны дарга)

С.Бат-Эрдэнэ (аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн ахлах мэргэжилтэн)

С.Өлзийбаяр (аймгийн Засаг даргын дэргэдэх Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн ерөнхий инженер)

С.Цэдэнсодном (Арвайхээр сумын Захирагчийн албаны ерөнхий менежер)

Л.Ганзориг (Арвайхээр сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Д.Батбаяр (аймгийн Цагдаагийн газрын хэсгийн байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч)

Н.Дэмбэрэлдулам (аймгийн Улаан загалмайн хорооны арга зүйч)

Ч.Даваасүрэн (аймгийн Засаг даргын дэргэдэх Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Ц.Гантулга (Онги-Таац голын сав газрын захиргааны мэргэжилтэн)

2.Ажлын төлөвлөгөө гарган батлуулж, 2021 оны 06 дугаар сарын 15-наас 09 дүгээр сарын 15-ны хооронд багтаан зохион байгуулан ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга (дэд хурандаа Д.Одонбаяр)-т үүрэг болгосугай.

3.Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 3,703,300 (гурван сая долоон зуун гурван мянга гурван зуу) төгрөгийг хавсралтаар баталсугай.

4.Дээрх зардлыг аймгийн Гамшгаас хамгаалах эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү,төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

Аймгийн Засаг даргын 2021 оны...06
 дугаар сарын 29-ны өдрийн 1/319 дүгээр
 захирамжийн хавсралт

ҮЕР, УСНЫ ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА
 ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ажиллах хоног	Нэг бүрийн үнэ/ төг/	Нийт үнэ / төг/
Анонс хэвлэх, тогтоох зардал						
1	Анонс	м	3x5	1	14 000	210 000
2	Уяа	м	25	1	1500	37 500
3	Шатахуун	л	20	1	2200	44 000
Самбарын зардал						
5	Төмөр	ш	10	2	62 000	682 000
6	Самбарын хөл, босоо төмөр	м	57	2	80 000	456 000
7	Цемент	шуудай	3	2	15 000	45 000
8	Хайрга	тн	1	2	50 000	50 000
9	Гагнуур хийх	Ажлын хөлс	6	2	30 000	180 000
10	Гагнуурын электрот	Хайрцаг	2	2	17 000	34 000
11	Самбар хэвлэл /150x90/	ш	11	2	18 000	198 000
12	Дайргын гол дээр хогийн сав, үер уснаас сэргийлэх самбар байгуулах	ш	2	2	356 000	712 000
Онги, Орхон гол дагуу завьт эргүүл хийх ажлын шатахууны зардал						
13	Шатахуун	л	18	24	1650	712 800
Хангайн сумдад ажиллах зардал						
14	Сум хоорондын шатахууны зардал	Км	300	3	99 000	99 000
15	Гол дагуу явах шатахууны зардал	Км	100	3	33 000	33 000
16	Хоол /5 хүн өдөрт 2 удаа/	удаа	30	3	7000	210 000
Нийт зардал						3,703,300